



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/59

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчидийн хурлын 2022 оны 08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 3 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж- аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулсан улсын залуу аварга тогооч шалгаруулах тэмцээнд оролцох үйл ажиллагааны зардалд 1,500,000 (Нэг сая таван зуун мянган) төгрөгийг зарцуулсугай.


2. Дээрх үйл ажиллагааны зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардлын 1,500,000 (Нэг сая таван зуун мянган) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй

4. Арга хэмжээг удирдамжийн дагуу зохион байгуулж, үр дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр)-т үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2023 оны
02 дугаар сарын 08 өдрийн
А.159 дугаар захирамжийн хавсралт

УЛСЫН АВАРГА ЗАЛУУ ТОГООЧ ШАЛГАРУУЛАХ
ТЭМЦЭЭНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зарцуулах чиглэл	Чиглэл	Хоног	Төлөх дүн	Оролцогчдын тоо	Нийт
1	Шатхууны зардал	Мөрөн – Булган-Мөрөн	3 хоног	200,000	15	600,000
		Мөрөн- Булган-Мөрөн	3 хоног	200,000		
		Мөрөн- Булган-Мөрөн	3 хоног	200,000		
2	Байр хоолны мөнгө		3 хоног	100,000	9	900,000
	Нийт					1,500,000

_____оОо_____